# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 653.9 сая, шилжих төсөл арга хэмжээнд 709.7 сая, нийт 1,363.7 сая төгрөгийн төсөв баталсан. 2023 оны 18 дугаар хуралдааны 3 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтыг 1,531.9 сая төгрөгөөр баталсан байна.

**Батлагдсан төсөвт өртөг: 1,531.9 сая**

**Төсөл арга хэмжээний тоо: 14**

**Шинэ**

**Төсөвт өртөг: 1,023.8 сая**

**Төсөл арга хэмжээний тоо: 7**

**Шилжих /Өмнөх оноос дамжсан/**

**Төсөвт өртөг: 508.1 сая**

**Төсөл арга хэмжээний тоо: 7**

## Төсөл, арга хэмжээний ангилал

**Их засвар**
384.2сая төгрөгийн 2 ТАХ

**Барилга байгууламж**
667.5 сая төгрөгийн 4 ТАХ

**Тоног төхөөрөмж**
259.3 сая төгрөгийн 4 ТАХ

**Зураг төсөв**
220.9 сая төгрөгийн 4 ТАХ

## Төсөл, арга хэмжээг салбараар авч үзвэл



Засаглал
/Төрийн байгууллага/
522.2 сая, 3 төсөл, арга хэмжээ, төсөвт өртгийн 34%



Дэд бүтэц
786.7 сая, 10 төсөл, арга хэмжээ, төсөвт өртгийн 51%



Нийгэм
223.0 сая, 1 төсөл, арга хэмжээ, төсөвт өртгийн 15%

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА



### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

**Орон нутгийн өмчийн газраас 2023 онд шинээр хэрэгжих 1,023.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж 1,012.3 сая төгрөгийн гэрээ байгуулах эрхийг олгож 11.5 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.**

**Харьцуулалтын арга:**
Төсөвт өртөг: 241.0 сая
Төсөл, арга хэмжээний тоо: 4

**Нээлттэй тендер шалгаруулалт:**
Төсөвт өртөг: 582.8 сая
Төсөл, арга хэмжээний тоо: 2

**Зөвлөх үйлчилгээ:**
Төсөвт өртөг: 200.0 сая
Төсөл, арга хэмжээний тоо: 1







## ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 50.0 хувьтай хэрэгжсэн байна.

2023 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 1,531.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээнээс 7 ажил гэрээний хугацаандаа хэрэгжээгүй дараа онд шилжсэн байна.

2021 онд 1, 2022 онд 4 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулсан нь нийт төсөвт өртгийн 37 хувийг эзлэх боловч 2024 оны эхний улирлын байдлаар ашиглалтад ороогүй, хэрэгжиж дуусаагүй байгаа нь нөлөөлж байна.

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**АУДИТААР НИЙТ 154.7 САЯ ТӨГРӨГИЙН 5 ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЖ, 154.7 САЯ ТӨГРӨГИЙН 3 АЛБАН ШААРДЛАГА, 2 ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН.**

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЗӨВЛӨМЖ

Он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулж, аймгийн ИТХ-аар батлагдсан хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч ажиллах, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах гэж заасныг хэрэгжүүлэх

## ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ЗӨВЛӨМЖ

Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг АИТХ-аар үнэн зөв батлуулах, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан тэгш боломжтой, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтлан төсөвт өртөгт өөрчлөлт оруулах бол шинээр сонгон шалгаруулалт зарлах, бусад тохиолдолд гүйцэтгэгч байгууллагад давуу эрх олгохгүй байх, гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй 7 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэхдээ алданги тооцох

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## АЛБАН ШААРДЛАГА-1

Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит монтаж засварын ажлыг хүлээн авах улсын комисс үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдаагүй, ажлын даалгавар, тоо хэмжээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байхад хүлээн авсан.

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ ДУТУУ



## АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГА ДАНС БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ



## АЛБАН ШААРДЛАГА-2

2. Тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан 803.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 732.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээнээс 89.9 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага данс бүртгэлд тусгаагүйгээс хөрөнгө эзэнгүйдсэн.

## АЛБАН ШААРДЛАГА 3

3. Талын илч ОНӨААТҮГ-т нийлүүлсэн 25.7 сая төгрөгийн цахилгааны нөөц үүсгүүрийн цэнэг хураагчид гарсан алдаанаас шалтгаалж зориулалтын дагуу ашиглаагүй.

## ЗУРАГ



АУДИТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАНГ WWW.OPEN.AUDIT.MN ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗЭХ БОЛОМЖТОЙ.